



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/239-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас:7036-2442 Цахим хаяг:Baasansurens@audit.gov.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15-16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16-17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17-18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
НББ	Нягтлан бодох бүртгэл
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.21 № СЭА-2022/239-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХОШУУЧ
Б.АТАРБАЯР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,523,197.66	79,611,945.68
35	БАРАА МАТЕРИАЛ	78,523,197.66	79,611,945.68
351	Түүхий эд материал	48,635,512.07	51,888,543.77
35110	Тусгай зориулалттай материал	48,635,512.07	51,212,043.77
35130	Эм боох материал	-	676,500.00
354	Хангамжийн материал	24,714,793.59	19,929,621.91
35410	Бичиг хэргийн материал	9,893,359.00	3,458,440.00
35420	Аж ахуйн материал	2,347,900.00	7,501,533.00
35440	Түлш, шатах тослох материал	8,864,612.59	4,697,040.91
35460	Хүнсний материал	108,000.00	745,700.00
35470	Бусад хангамжийн материал	3,500,922.00	3,526,908.00
35600	Мал амьтад	5,172,892.00	7,793,780.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,222,983,298.63	1,266,830,382.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,222,983,298.63	1,266,830,382.64
392	Биет хөрөнгө	1,056,023,298.63	1,100,003,715.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,231,456.50	760,231,456.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,363,636.52)	(75,130,598.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	244,323,035.04	306,164,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,787,068.83)	(44,574,555.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	182,149,118.85	155,468,942.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,225,639.41)	(45,737,931.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,351,643.89	23,697,943.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,272,515.89)	(13,732,445.89)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	33,616,905.00	33,616,905.00
393	Биет бус хөрөнгө	166,960,000.00	166,826,666.68
39301	Программ хангамж	800,000.00	800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(133,333.32)
39303	Бусад биет бус хөрөнгө	166,160,000.00	166,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,301,506,496.29	1,346,442,328.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,301,506,496.29	1,346,442,328.32
51	Засгийн газрын хувь оролцоо	1,301,506,496.29	1,346,442,328.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	595,746,480.28	595,746,480.28
51101	Өмч: - төрийн	595,746,480.28	595,746,480.28
512	Хуримтлагдсан үр дүн	110,272,524.36	155,208,356.39
51210	Өмнөх үеийн үр дүн	110,272,524.36	110,272,524.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	44,935,832.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	595,487,491.65	595,487,491.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,301,506,496.29	1,346,442,328.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,260,370,678.55	1,869,886,298.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,761,578.55	234,593,798.18
120	Нийтлэг татварын бус орлого	95,761,578.55	234,593,798.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,239,550.00	51,524,779.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,074,550.00	8,214,529.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	63,165,000.00	43,310,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,164,609,100.00	1,635,292,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,163,109,100.00	1,632,292,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,163,109,100.00	1,632,292,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	3,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,195,415,530.02	1,824,950,466.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,195,415,530.02	1,824,950,466.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,193,235,530.02	1,815,317,917.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,754,496.00	1,425,307,400.00
210101	Үндсэн цалин	582,108,053.00	844,384,781.00
210102	Нэмэгдэл	355,646,443.00	580,922,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,094,308.00	31,003,400.00
210201	Тэтгэврийн даатгал	-	380,190.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	281,920.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	160,960.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	190,960.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,094,308.00	29,989,370.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,584,309.00	50,251,900.00
210301	Гэрэл, цахилгаан	13,181,626.00	15,306,696.00
210302	Түлш, халаалт	12,560,000.00	29,147,207.00
210303	Цэвэр, бохир ус	3,842,683.00	5,797,997.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,128,826.00	84,387,769.68
210401	Бичиг хэрэг	4,825,475.00	6,188,520.00
210402	Тээвэр, шатахуун	43,534,934.00	56,895,633.68
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,334,797.00	5,843,667.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,013,620.00	7,456,850.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	-	7,728,099.00
2105	Нормативт зардал	12,891,500.00	19,849,580.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	655,000.00	1,124,980.00
210502	Хоол, хүнс	11,653,500.00	18,474,300.00

**Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	583,000.00	250,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,300,615.00	24,525,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,160,060.00	439,500.00
210604	Урсгал засвар	14,140,555.00	24,086,100.00
2107	Томилолт, зочны зардал	5,121,000.00	4,178,000.00
210702	Дотоод албан томилолт	5,121,000.00	4,178,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,220,608.00	1,695,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	886,000.00	961,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	400,000.00
210807	Газрын төлбөр	-	100,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	147,608.00	234,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,139,868.02	174,119,167.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	332,550.00	2,558,414.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,307,318.02	168,560,752.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,180,000.00	9,632,549.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,180,000.00	3,580,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,180,000.00	3,280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,052,549.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,052,549.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	64,955,148.53	44,935,832.03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,154,165.33	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,154,165.33	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(32,154,165.33)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	32,800,983.20	44,935,832.03

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,503,441,800.00	1,643,507,029.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,848,100.00	8,214,529.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,848,100.00	8,214,529.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,848,100.00	8,214,529.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,848,100.00	8,214,529.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,497,593,700.00	1,635,292,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,496,093,700.00	1,632,292,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,496,093,700.00	1,632,292,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	3,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,503,441,800.00	1,643,507,029.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,503,441,800.00	1,643,507,029.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,493,849,890.00	1,633,874,480.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,301,211,428.00	1,425,307,400.00
210101	Үндсэн цалин	807,733,428.00	803,982,762.00
210102	Нэмэгдэл	493,478,000.00	621,324,638.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,008,043.00	31,003,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,008,043.00	31,003,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,778,400.00	50,251,900.00
210301	Гэрэл, цахилгаан	16,986,290.00	15,306,696.00
210302	Түлш, халаалт	22,054,384.00	29,147,207.00
210303	Цэвэр, бохир ус	5,737,726.00	5,797,997.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,209,300.00	67,450,800.00
210401	Бичиг хэрэг	6,352,000.00	6,502,100.00
210402	Тээвэр, шатахуун	52,273,700.00	52,143,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,863,600.00	5,843,667.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	275,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,300,000.00	2,686,333.00
2105	Нормативт зардал	19,832,500.00	19,650,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	299,980.00
210502	Хоол, хүнс	19,099,500.00	19,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	583,000.00	250,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,916,135.00	29,071,700.00

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,999,560.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	20,916,575.00	26,071,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,121,000.00	4,178,000.00
210702	Дотоод албан томилолт	5,121,000.00	4,178,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,148,084.00	1,461,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	886,000.00	961,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	400,000.00
210807	Газрын төлбөр	75,084.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,625,000.00	5,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,125,000.00	2,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,591,910.00	9,632,549.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,610,000.00	3,580,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,310,000.00	3,280,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,981,910.00	6,052,549.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,981,910.00	6,052,549.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	637,521,131.65	104,095,924.19	1,337,363,536.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	42,033,640.00	42,033,640.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,746,480.28	637,521,131.65	146,129,564.19	1,379,397,176.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	32,800,983.20	32,800,983.20
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	110,272,524.36	1,301,506,496.29
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	110,272,524.36	1,301,506,496.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	110,272,524.36	1,301,506,496.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	44,935,832.03	44,935,832.03
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	155,208,356.39	1,346,442,328.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,637,292,500.00	1,640,507,029.00	3,214,529.00	100.19
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,637,292,500.00	1,640,507,029.00	3,214,529.00	100.19
210	Бараа, үйлчилгээний зардал	1,633,712,500.00	1,630,874,480.00	2,838,020.00	99.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,425,307,400.00	1,425,307,400.00	-	100.00
210101	Үндсэн цалин	808,118,700.00	803,982,762.00	(4,135,938.00)	99.49
210102	Нэмэгдэл	617,188,700.00	621,324,638.00	4,135,938.00	100.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,003,400.00	31,003,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,003,400.00	31,003,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,251,900.00	50,251,900.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	15,225,800.00	15,306,696.00	80,896.00	100.53
210302	Түлш, халаалт	25,222,200.00	29,147,207.00	3,925,007.00	115.56
210303	Цэвэр, бохир ус	9,803,900.00	5,797,997.00	(4,005,903.00)	59.14
2104	Хангамж, бараа материалын зардал	67,450,800.00	67,450,800.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	6,352,000.00	6,502,100.00	(150,100.00)	102.36
210402	Тээвэр (шатахуун)	52,293,800.00	52,143,700.00	150,100.00	99.71
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	5,725,000.00	5,843,667.00	(118,667.00)	102.07
210404	Ном, хэвлэл	120,000.00	-	120,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	275,000.00	385,000.00	41.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,300,000.00	2,686,333.00	(386,333.00)	116.80
2105	Нормативт зардал	19,650,300.00	19,650,280.00	20.00	99.99
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	299,980.00	20.00	99.99
210502	Хоол, хүнс	19,100,000.00	19,100,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	250,300.00	250,300.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	30,262,100.00	29,071,700.00	1,190,400.00	96.07
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	27,262,100.00	26,071,700.00	1,190,400.00	95.63
2107	Томилолт, зочны зардал	5,575,600.00	4,178,000.00	1,397,600.00	74.93
210702	Дотоод албан томилолт	5,575,600.00	4,178,000.00	1,397,600.00	74.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,711,000.00	1,461,000.00	(250,000.00)	16.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	250,000.00	-	250,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	961,000.00	961,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	400,000.00	400,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,580,000.00	9,632,549.00	6,052,549.00	269.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,580,000.00	3,580,000.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	300,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,280,000.00	3,280,000.00	-	100.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,637,292,500.00	1,640,507,029.00	3,214,529.00	99.76
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,632,292,500.00	1,632,292,500.00	-	99.56
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,632,292,500.00	1,632,292,500.00	-	99.56
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	8,214,529.00	3,214,529.00	164.45
1200041	Туслах үйл ажиллагааны орлого	5,000,000.00	8,214,529.00	3,214,529.00	164.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96.00	96.00	-	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	93.00	93.00	-	-
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,500,000.00	3,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,500,000.00	3,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,500,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	3,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,500,000.00	3,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	3,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтэс / Цаашид Мандал сум дахь Цагдаагийн хэлтэс / -ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой, анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Цагдаагийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 42/2-130 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сум дахь Цагдаагийн хэлтэс нь “ *Нийтийн хэв журмыг сахиулан хамгаалах, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах.* ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Мандал сум дахь Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх,
- Нийгмийн хэв журам сахиулах,
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах,
- Захиргааны хяналт тавих үүрэг гүйцэтгэх буюу хуулиар хүлээлгэсэн хуулийн биелэлтэд хяналт тавих.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус хэлтсийн мөрдөж байгаа НББ-ийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс тусгайлсан дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.


Мандал сум дахь Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,195,415.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,931.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 13,448.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сум дахь Цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,935.8 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	78,523.1	79,611.9	1,088.8
Үндсэн хөрөнгө	1,222,983.3	1,266,830.3	43,847.0
Нийт хөрөнгө	1,301,506.4	1,346,442.2	44,935.8
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,301,506.4	1,346,442.3	44,935.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,301,506.4	1,346,442.3	44,935.8

Бараа материалын дансны үлдэгдэл 79,611.9 мянган төгрөг болж 1,088.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 100,597.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ЦЕГ-аас 10,850.6 мянган төгрөг / хувцас, хамгаалах хэрэгсэл, үнэт цаас/-ийн, НИК ХХК-аас 500.0 мянган төгрөгийн шатахууны талоны урамшуулал, 7,793.8 мянган төгрөгийн малын нас дэвшилт зэрэг нийт 19,143.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 118,652.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,446,139.2 мянган төгрөг болж өмнөх оноос 31,507.1 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХО-ын санхүүжилтээр 150,000.0 мянган төгрөгийн Ланд крузер 200 маркийн 1 авто тээврийн хэрэгсэл, ЦЕГ-аас 9,500.0 мянган төгрөгийн Хьюндай элентра маркийн 3 авто тээврийн хэрэгсэл, 6,603.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, Мандал сумын ГХУС салбар зөвлөлөөс 5,699.4 мянган төгрөгийн компьютер зэрэг нийт **171,802.8** мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймгийн ИТХТ-ийн тогтоолоор 57,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4 авто тээврийн хэрэгслийг аймгийн ОНӨГ-т шилжүүлж, элэгдлээрээ өртгөө нөхсөн 63 нэр төрлийн хөрөнгийг 40,605.0 мянган төгрөгөөр дахин үнэлж, орлогод бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,346,442.3 мянган төгрөг болж 44,935.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 609,515.6 мянган төгрөгөөр буюу 32.5 хувиар өссөн нь үйл ажиллагааны санхүүжилт 470,683.4 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 138,832.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 629,534.9 мянган төгрөгөөр буюу 34.5 хувиар өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал 622,082.4 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хэлтсийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг тус бүр 1,644,542.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг өөрчлөлт оруулалгүйгээр баталсан бол 12 дугаар сард өөрчлөлт оруулан 7,250.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,637,292.5 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,637,292.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, улсын төсвөөс 1,632,292.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,632,292.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 5,000.0 мянган төгрөг зэрэг нийт 1,637,292.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн үйл ажиллагааны урсгал зардалд 1,634,454.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,634,454.5 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь урсгал засварын зардал 1,190.4 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардал 1,397.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 250.0 мянган төгрөг зэрэг нийт **2,838.0** мянган төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант оны эцэст төсвийн хэмнэлт **2,838.0** мянган төгрөг болон үндсэн үйл ажиллагааны давсан орлого **3,214.5** мянган төгрөг зэрэг нийт 6,052.5 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Цагдаагийн газраас хар тамхины ургамал устгах арга хэмжээний зардалд 3,000.0 мянган төгрөг хуваарилагдсан бөгөөд 2,000.0 мянган төгрөгийг шатахууны, 1,000.0 мянган төгрөгийг хүнсний материалд зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд онцлог бусад асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал сум дахь Цагдаагийн хэлтэс нь тайлант онд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 141 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 8 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	4	3,118.5	4	3,118.5	100.0
Нийт дүн	4	3,118.5	4	3,118.5	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1. ЦЕГ-аас 2021 оны 12 дугаар сард балансаас балансад шилжиж ирсэн нийт 9,500.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 суудлын автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь тус хэлтсийн эзэмшилд бүртгэгдээгүй байгаа нь Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.2 дахь “Өмчлөгч нь энэ журмын 3.1-д заасан шилжилт, хөдөлгөөнийг 7 хоногийн дотор хийлгэх үүрэгтэй.”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (а)-д тодорхойлсон заалттай нийцээгүй ба “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд 2022 оны 2 дугаар улиралд багтаан тээврийн хэрэгслийг байгууллагын эзэмшилд шилжүүлэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18,846.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, цаашид алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 5 зөвлөмж өгөв.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ЦЕГ-аас 2013 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах.

1.2.1 Илрүүлэлт: Ажлын үр дүнгээр сахилгын шийтгэл ногдуулж, давхардсан тоогоор 66 алба хаагчийн цалин хөлсийг 9,901.3 мянган төгрөгөөр бууруулахдаа цалингийн цэсийн нэмэгдэл талд хасах утгаар оруулж цалингийн тооцоолсон өглөгийг бууруулж, цалингийн зардлыг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын ажиллагчидтай холбогдсон зардлын бүртгэлийн 3.6 дахь “Тайлангийн хугацааны цалингийн зардлыг дараах байдлаар бүртгэнэ: 3.6.(б) дэх “Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ. Дт.өглөг-Цалингийн тооцооны Кт.Бусад өглөг-ажиллагчийн төлөх бусад суутган төлбөр” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид цалингийн тооцооллын бүртгэлийг зааврын дагуу зөв хийж гүйцэтгэх.

1.3.1 Илрүүлэлт: 2020 онд НДШ-ийн илүү төлөлтөөс үүссэн 1,460.4 мянган төгрөгийн авлагыг 2021 оны санхүүгийн тайланд оны эхний үлдэгдлээр бүртгэж, тайлагналгүйгээр тайлант жилийн төлбөрөөс нөхөн суутгасан байна.

1.3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:” “14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:” 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.7.” аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, ...” гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

2. Анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 7,484.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан

загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн тул цаашид Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Цагдаагийн хэлтэс	5	18,846.4	-	-	-	-	-	-	5	18,846.4